

**ЗҮҮНГАРЫН ТЭРГҮҮЛЭГЧИД: ХААН УУ?
ХАН УУ? ЭСВЭЛ ХУНТАЙЖ ЮМ УУ?**

И. Саруул
/МУИС-ийн НШУС-ийн багш/

Өгүүллийн товч: Зүүнгарын судалгаанаас үзэхэд тэргүүлэгчдийг нь хунтайж, хан, хаан гэх мэтээр төрөл бүрээр цоллосон байна. Чухам аль зөв бэ? гэсэн асуудал тавигдаж буй. Зүүнгарын төр нийгмийн хөгжлийн статусаар нь хөөж үзвэл үндсэн цол нь хунтайж байжээ. Хан цолыг түвдээс олгож байсан бөгөөд хавсарсан тодотгол төдий байжээ. Энэхүү хан цол нь монгол дуудлагаар сунжирч хаан болж дуудагдсан байна. **Түлхүүр үг:** Хан, хаан, Зүүнгар улс.

Өнөөдөр Монголын түүхийн зарим асуудал эргэлзээ төрүүлэх тул эргэж нягтлах шаардлагатай байна. Дундад зууны түүх бичлэгт л гэхэд баруун монголын тэргүүлэгчдийг хан, хаанаар цоллосон ялгаатай хувилбарууд олонтаа тааралдана. Хэсгээс нь харуулбал: - Монгол улсын дунд сургуулийн Монголын түүхийн сурах бичигт: - “Галдан 1671 онд хаан ширээнд суужээ”, “Цэвээнравдан хаан”, “Галданцэрэн хаан”, “Даваач хаан” (1.т.160-162.) гэсэн байхад Монголын түүхийн бага нэвтэрхий толь бичгийн Ш ботид: - “Зүүнгарын хант улс”, “Цэвээнравдан хан”, “Галданцэрэн хан”, “ойрадын ханы сүр хүч” (2.т.118,140,86.) гэх мэт байна. Эрдэмтэн судлаачдын ном зохиолд ч чорос аймгийн толгойлогчдын цол хэргэмийг зэрэгцүүлсэн явдал арвин буй. Гагцхүү төр улсын ямар утга агуулга шингээсэн нь тун ойлгомжгүй, эргэлзээтэйн дээр тэдний санал ч зөрөлдөнө. Тиймээс ч академич Ч. Далай: - “Галдан бошогт хаан, хан хоёрын аль нь байсан зэрэг олон асуудал өнөөдөр тэр бүр тодорхой бус юм. Энэ талаар дотоод, гадаадын олон эрдэмтэд янз бүрээр л тайлбарлажээ (3.т.134.) гэсэн болбуу. Хаан бол тусгаар төр улсын гагц тэргүүн эзэн, хан бол улсын хэсэг бүрэлдэхүүний тэргүүлэгч тул утга агуулгын ялгаатай ойлголтууд юм. Өдгөө Зүүнгарын хан, хаан цолны аль нь зөв, түүх бичлэгт чухам алийг нь хэрэглэвээс зохилтойг цэгцлэн шийдэх шаардлагатай байна.

Хэсэг эрдэмтдээс Зүүнгарын тэргүүлэгчдийг хаан цолтой гэсэн саналыг нягталбал түүхэн зүтгэлтний хувьд онцгойлж Галдан бошогтыг их төлөв хаанд өргөмжилж, бусдыг хан хэмээн ховорхон тохиолдлоор хаанаар цоллосон харагдана. Тухайлбал, - “1634 онд Зүүнгарын хаан ширээнд чорос буюу Зүүнгар аймгийн Баатар хунтайж (1634-1665) суужээ” (3.т.14.); Намсрай: - “1678 онд Далай ламаас Галдан бошогтод хаан цол шагнажээ” (4.т.94.); - Академич Ч. Далай: - “1678 онд Энх-Амгалан хаанаас хаан цолыг Галданд өгсөн тухай сурвалж бичигт тэмдэглэсэн байдаг” (3.т.141.); Баабар: - “Энэ үед Чингийн эзэн хаанаар тодорч бүх амьдралаа монголчуудтай харилцахад зориулсан Кан Си 1678 онд Галданд хаан цол шагнав” (5.т.180.) гэжээ. Эдгээр зэрэг заалтанд анхаарал татсан зүйл бол Галдан бошогтод хаан цолыг түвдийн Далай лам уу?, эсвэл манжийн Энх-Амгалан хаан шагнасан тал дээр зөрчилдөнө.

Манжийн хаанаас шагнасан гэсэн нь бодвол Зүүнгарын улс тусгаар тогтносон манжийн Чин улстай эн тэнцэх улс тул манжийн Энх-Амгалан хаан зөвшөөрсөн санаа гаргахыг оролдсон болов уу. Гэвч түрэмгийлэн эзлэхээр завдаж буй улсын эзэн дайсан ард түмний тэргүүлэгчид хариас хаан цол

олгох болов уу? Тэр тусмаа Энх-Амгалан хаан Галдан бошогтыг хаан цолоор шагнаж өөртэйгээ эн зэрэгцүүлэх үү? Галдан бошогт хан цол хүртсэнээ Энх-Амгалан хаанд мэдэгдэхэд тэр ихэд дургүйцжээ. Энэхүү санааг тавигсад зохиолдоо хаанаас ямар баримт олж үзсэнээ ер ишилсэнгүй, тэгээд ч ийм баримттай сурвалж хараахан олдоогүй билээ. Мөн түвдийн Далай ламаас хаан цол олгосон заалттай сурвалжийн баримт байхгүй нь тодорхой, тэгээд ч хаан цолыг гаднаас олгосон түүх олдохгүй биз ээ.

Хаан цол хэдий бэлгэдлийн ёс төдий илрэвч мөн чанартаа нийгэм, төр улс, цэргийн байгуулалт, ёс суртахууны зэрэг олон хүчин зүйлээс бүрдсэн нарийн утга агуулга тодорхойлсон ухагдахуун билээ. Тэр тусмаа дундад зууны Азийн улс орнуудын түүхэнд хаан бол тусгаар тогтносон бүрэн эрхт улсын эзэн юм. М. Санждорж: - “Дорно дахины орнуудад өөрийн хаан байваас улсаа байж байна гэж үздэг уламжлалтай” (6.т.20.) хэмээн тодорхойлсон байдаг. Хаан байваас тусгаар тогтносон улс оршино, улс нь оноосон нэртэй тунхаглагдана зэрэг өвөр хоорондоо салшгүй хүйн холбоотой, харилцан нөхцөлдсөн холбоо бүхий төр улсын тогтнол юм. Монголын дундад үеийн түүхэнд баруун монголчуудаас Тогоон, Эсэн нар л Монгол улсын хаан ширээнд сууж байжээ. И.Я. Златкины тэмдэглэснээр: - “Тогоон, Эсэн хоёр албан ёсоор хаанд өргөмжлөгдөж байгаагүй” (7.т.51.) бөгөөд М. Санждоржийн зохиолд: - “Тогоон тайш өөрийгөө Монголын хаан гэж зарлаж байжээ” (6.т.63.).

Зарим нөхөд Галдан бошогтыг тусгаар улс байгуулсан тул түүнд хаан цол шагнав гэж бичиж байна. Тэгвэл Галдан бошогт тусгаар улсын тэргүүн байв уу? Эрдэмтэн судлаачдын бүтээлээс сурвалжлахад харин ч үгүйсгэсэн хандлагатай нь тодхон харагдана. Тухайлбал, академич Ш. Нацагдорж: - “Галдан Зүүнгарыг нэгтгэн захирсан боловч нүүдлийн аймгийн эзэн юм” (8.т.57.); Мияваки Жюно: - “Галдан 1671 онд Чоросын удирдагч байсан бөгөөд Галдангийн дараах Зүүнгарын удирдагч хаан цолгүй байсан. XVII-XVII зуунд Төв Евразийн нутгийг эрхшээлдээ оруулсан Зүүнгар нь тус аймгийг удирдагчаа болгосон Ойрадын аймгийн холбоо байв” (9.т.83.) гэжээ. “Ойрадын аймгийн холбоо” гэсэн нь Галдан бошогтын үед Зүүнгар нь хараахан улсын зэргэмжинд хүрсэнгүй, хэдий бие даасан ч Монгол улсынхаа бүрэлдэхүүний хэсэг гэж төр улсын тогтнолын статусыг ханлигаар тодорхойлжээ. Хожим Зүүнгар нь улс болж хөгжсөн цагт ч түүнийг тэргүүлсэн Цэвээнравдан, Галданцэрэн хунтайжууд ч хаан цолгүй байлаа. Сурвалж баримтанд харь хөндлөнгөөс хан цол олгосон гэснийг түүхчид Галдан бошогтыг онцлон хаан цолтой хувиргажээ. Түвдээс олгосон хан цолыг хаан болгон дэвшүүлж байгаа бол тухайн үед олон монгол ноёд түвдээс хан цол хүртсэн, тэднийг яахав? Хан цолыг Түвд л мэддэг онцгой эрх болно, яавч тийм баймгүй. М. Санждоржийн тэмдэглэснээр: - “Баруун монголчууд хэдий Зүүн Монголтой олон удаа (1552, 1562, 1574, 1587, 1608, 1619) сэлэм зөрүүлж нэг дийлж, нэг дийлэгдэж байсан боловч Дөчин дөрвөн хоёрын Монгол улсын бүрэлдэхүүнээс гараад явчихсангүй” (6.т.72.) гэсэн нь бас хаан цол байх нөхцөлгүйг харуулна. Бас Галдан бошогт, Цэвээнравдан хоёрыг эвлэрүүлэх зорилгоор 1693 онд түвдийн дэсрид Санжаажамц Далай ламын нэрээр Цэвээнравданд тамга бичиг ирүүлж: - “Алтайн нуруунаас баруун тийшээх хан” (19.т.25.) олгожээ. Энд хан цолтон бол улсын тэргүүн бус, улс орны зарим хэсгийг захирсан тэргүүлэгчийг зааж буй харагдана.

Чоросын тэргүүлэгчдийг хан цолтой гэсэн санааг тодотговол Галдан бошогтыг Зүүнгарын нутагт оршин байсан овог аймгуудыг нэгтгэсэн даруйд түвдийн Далай ламаас хан цол шагнажээ. Бошогт цолны талаар академич Ш. Нацагдорж: - “Энэ нь бурхан тэнгэрийн бошгоор хан болсон хүн гэх санааг агуулсан байжээ” (8.т.57.) гэсэн байхад Баабар: - “1679 онд Далай лам Тэнгэрийн соёрхол гэсэн утгатай бошгот цолыг өөрийн шавь ба өөрийн хамгаалагчид хайрласан” (5.т.180.) гэх мэтээр тайлбарлажээ.

Энд Галдан бошогт хэдэн онд хан цол олсон хугацаа өнөө хир тогтоогдоогүй байна. Дунд сургуулийн Монголын түүхийн сурах бичигт: - “Эрдэнэбаатар хунтайжийг нас барсны дараа түүний хөвгүүдийн дунд хан ширээний төлөө тэмцэл өрнөв. Эцэст нь Галдан 1671 онд хан ширээнд суужээ” (1.т.160); - Академич Ш. Нацагдорж: - “Галданыг 1679 онд Далай ламаас бошигт хан цол өгсөн” (8.т.57.); - Академич Ч. Далай: - “1678 онд Далай ламаас хүртээсэн Галдан данжун бошогт хаан хэмээх цол соёрхсон тамгатай бичгийг Галдан хунтайжид өргөн барьжээ” (4.т.65;3.т.141.) гэсэн заалтуудтай ямагт учирна. Ерөнхийдөө 1671, 1676, 1678, 1679 гэсэн хэдэн оны хувилбар түүхийн ном зохиолд бий.

Судлаачдын санал нэгтэй тогтоосон зүйл бол Баатар хунтайжийн хүү Сэнгэ хунтайж 1670 он хүртэл Зүүнгарын аймгийг захирч байтал чоросын дээдсийн дунд хагарал гарч түүний амийг хороожээ. “Сэнгэ хорлогдсоны дараа чорос аймгийг даргалах хунтайж цолыг чухам хэнд олгох тухай асуудал тулгарсан” (10.т.77.). Түвд орноос Сэнгэ хунтайжийн дүү Галдан нутагтаа буцаж ирээд “1671 онд чорос аймгийн бүх эрхийн бэлэг тэмдэг болсон хунтайж цолыг авсан” (10.т.83.) байна. Хунтайж цолыг Баатар хунтайж Зүүнгар аймгийг байгуулаад анх үндэслэсэн болно. БНМАУ-ын түүхийн II ботид: - “Баатар хунтайж 1635 оноос хойш өөрийгөө хунтайж гэж нэрлэх болсон” (11.т.71.), тэр цагаас чорос аймгийн эзний цол болжээ. 1638-1660 онд Эрдэнэ Баатар хунтайж, 1660-1671 онд Сэнгэ сэцэн хунтайж, 1671-1679 онд Галдан бошогт хунтайж, 1697-1727 онд Цэвээнравдан эрдэнэ зоригт хунтайж, 1727-1746 онд Галданцэрэн эрдэнэ баатар хунтайж, 1746-1749 онд Цэвээндорж Аджа намжил хунтайж, 1749-1753 онд Ламдорж эрдэнэ баатар хунтайж, 1753-1755 онд Даваач хунтайж цолтой явжээ. Тэхлээр хунтайж цол бол нийтээр зөвшөөрсөн чорос аймгийн үндсэн цол юм. Харин Галдан бошогтоос эхлэн зөвхөн чорос аймгийн эзний төдий бус нийт Зүүнгарт оршигч ойрад түмний тэргүүлэгчийн цол болжээ. Тэднээс Галдан бошогт, Цэвээнравдан, Галданцэрэн гурав түвдээс хан цол олсон байна.

1678 он бол Галдан бошогт Зүүнгарын нутагт оршин байсан овог аймгуудыг чорос аймагт захируулж, Зүүнгарын нэгдэл байгуулагдсан жил билээ. Тэр онд Зүүнгарын оршин тогтнож буй статуст тохируулж Далай ламаас Галдан бошогтод хан цолны шагнал илгээжээ. Дайчин улсын магад хуулийн Энх-Амгалан хааны 18-р оны 9 дүгээр сарын нохой өдрийн зурваст: - “1678 оны билгийн улирлын 6 сарын 30-ны өдөр Жирбун (элч – И.С.) Лхасаас мордож өвлийн улирал нь сая ойрадад ирээд Далай ламаас Галдан данжун бошогт хан хэмээн цол хүртээсэн тэмдэгт бичгийг тушаажээ” (10.т.94.) гэсэн сурвалжийн заалт буй тул Галдан бошогт 1678 оны өвөл цагт хан болжээ.

Хан бол Монголд эртнээс хэрэглэгдсэн уламжлалтай, улсын бүрэлдэхүүний салбар хэсгийн тэргүүлэгч ноёдын цол хэргэм юм. Гүр хан, Ван хан, Таян хан гэх зэрэг эзэнт гүрний үед хувь улсуудын тэргүүтнийг алдаршуулсан, эхэндээ хурлаар сонгогдож байгаад хожим үе залгамжилсан билээ. ХҮ1 зууны эцэст Халхад бараг нэгэн зэрэг гурван хан гарчээ. Анх Гэрсэнзийн гутдугаар хүү Ноонох үйзэнгийн ахмад хүү Автай /1554-1588/ Содномжамц Далай ламаас /1577-1652/ 1577 онд Очирбат түшээт хан цол, удаад нь Гэрсэнзийн тавдугаар хүү Аминдуралын ач Шолой /1577-1652/ Махасамадий гэгээн сэцэн хан цолтой болжээ. Дараа нь Гэрсэнзийн ахмад хүү Ашихайн ач Лайхур өөрийгөө Засагт ханд өргөмжилсөн. Эдгээр ханууд хэрэг дээрээ хошууны засаг ноёдын адил эрх мэдэлтэй байв (12.т.118). Зүүнгар нь мөн л Монгол улсын өрнө талын ард түмэн буюу баруун жигүүрийг захирсан Галдан бошогтын цагт Зүүнгар нь хэдий бие даасан байдалтай ч Монгол улсынхаа бүрэлдэхүүний хэсэг байжээ.

Хан цол зүгээр ч нэг гараад ирчихгүй, бий болсон өөрийн гэсэн түүхэн нөхцөл учир шалтгаантай үзэгдэл юм. Монгол улс задарч Монгол улсын хэсэг бүрэлдэхүүнүүд харьцангуй бие даасан нөхцөлд хошуучлагч нар шаардагдсантай холбоотой хан цолтонгууд гарчээ. Эхэндээ аймаг тус бүрийн чуулганаар дэвшигч этгээдүүдийг шигшин хэлэлцэж тохоож байсан бол хожим манжийн хараат байдалд орсон цагаас манжийн хаанаас томилсон зэрэг явдал халхын Сэцэн ханы зэрэг жишээгээр харагдана. Б. Оюунбилиг: - “Шолойгоос Норов хүртэл анхны гурван хан бүр Халхын зүүнгарын дөрвөн хошууны ноёдын чуулганаар батлагджээ. Тэр үед бол Халхын улс төрийн тусгаар байсан цаг юм. Харин Илдэн Равдан бол манжийн хааны шууд зарлигаар сэцэн хан болж, Халхын ноёд хутугт бүхний дэмжлэгийг олсонгүй. Энэ явдал гарсан нь гэнэтийн биш, харин Халхын дотоод самуурал Халх ханлигийн хүчийг бууруулж, манж нар Халхын улс төрд хөндлөнгөөс гар дүрж, цаашлаад Халхын хаад ноёдыг томилох эрхийг ч гартаа оруулж авсан явдал юм. Шолойгоос Илдэн Равдан хүртэлх дөрвөн сэцэн ханы явдал нь 1635 онд Их Монгол Улс мөхсөнөөс сүүлээрх Халхын улс төрийн замнал ба хувь заяаны үндсэн эргэлтийг нэг талаас нь харуулжээ” (18.т.227.) гэснийг анхаарууштай.

Ойрадын Зүүнгат хан цолтон гарч ирсэн нь нийт Монгол даяарт ханууд гарч ирсэнтэй цаг хугацааны хувьд давхцана, тэхдээ Зүүн Монголын хануудаас онцлогтой байна. Баруун Монголын зонхилох дөрвөн аймгийн чуулганаар батлагдсан тэргүүлэгч нарыг хан цолтон өргөмжилснөөс хойш ойрадад хан цолтонгууд бий болжээ. Тухайлбал, Аюук хан, Хөх нуурын Гүүш хан, Очирт сэцэн хан зэрэг. Энэ нь нэг эзний бүрэн эрх мэдэлд хураагдсан гэсэн үг биш. Зүүнгарын голлох дөрвөн аймгийн нэгнийх нь эзэн төдий, ойрадын чуулганы даргын албыг түр хугацаанд хашигч нөхөр юм. Их төлөв ойрадад хүчирхэг аймгийн тэргүүлэгчид тохоогдон ээлжлэх хандлагатай явжээ. Харин Галдан бошогтоос эхлэн хан цолны агуулга нь өөрчлөгджээ. 1671 онд Галдан бошогт Ойрадын чуулганыг тарааснаар аймгуудын холбооны даргын утгатай хан цол байхгүй болжээ. 1678 онд Галдан бошогт Зүүнгарын түмнийг гартаа нэгтгэн төвлөрүүлж, Монгол улсын баруун түмний бие гагц эзэн болжээ. Энэ явдалтай холбоотой түвдийн Далай лам Галдан бошогт, Цэвээнравдан, Галданцэрэн нарыг хан цолоор шагнажээ. Харийнхны олгосон хан цол давхар батламж төдий зэрэглэл болно. Учир нь

Галдан бошогт Сэнгэ ахаасаа чорос аймгийн толгойлогчийн хунтайж цолыг залгамжилсан, дараа нь Зүүнгарын ойрад нь Галдан бошогтын мэдэлд төвлөрч, чуулган тарааж хан цолтонгүй болгосон болохоор хунтайж нь Зүүнгарын гагц эзний дээд цол, хан цолтонтой адил эн зэрэгцэх толгойлогчид оноодог цол болжээ.

Ер нь тухайн үед баруун монголын ноёд бүгд Түвдээс хан цол хүртэцгээсэн. Төв Азийн улс төрийн хүчний байдал, Түвд орныг хамгаалж чадах холбоотны үндэслэлээр тал татаж олгосон шагнал төдий юм. “Түвдийн байр суурь, нөлөөгөө дэлгэрүүлэн өргөтгөхдөө монгол ноёдын зэвсэгт хүчээр түшиг болгож байсан”-тай (10.т.82.) холбоотой. Нөгөөтэйгүүр Түвдээс монгол ноёдод хан цол тараасан явдал өвөр хооронд хагаралдуулан тэмцэлдэхэд хүргэсэн, эн зэрэгцсэн хан болцгоож бие биенээ дарамтлах, хэргэм зэрэг, өмч хөрөнгө, нутаг бэлчээр, албат харъяатаа булаацалдах шалтгаан болж байжээ. Зүүнгарын тэргүүлэгчид Зүүн Монголын тэргүүлэгчидтэй зөрчилдөх болсон шалтгаан мөн үүнтэй ч холбоотой.

Сонирхолтой нь Галдан бошогт, Цэвээнравдан, Галданцэрэн нар хан цолоо яг түвдийн Далай ламаас хүртээгүй ажээ. Тэр үед Далай лам нас нөхцсөн тул түвдийн ерөнхий сайд дэсрид див Санжаажамц манжийн Энх-Амгалан хаанаас чандлан нууцалсан цаг тул Далай ламын нэрээр тамгат бичиг хүргүүлж олгож байжээ.

Галдан хан цол хүртмэгцээ манжийн Энх-Амгалан хаанд элч зарж мэдэгдэхэд үл хүлээсэн тухай Бодлогын бичгийн 1-р дэвтэрт: - “Өөлдийн аймагт угаасаа Очирт хан Абалай ноён, Галдан тайж хэмээж алба барин явсан бөлгөө. Ер бошогт хан хэмээн элч явсан газаргүй” (8.т.57.) гээд халгаасангүй. Хожим “Цэвээнравдан хунтайж Галдан бошогт ханы орыг залгамжлан өөлдийн хан сууж, манжийн хаанд мэдэгдэн айлтгасанд манжийн хаанаас хан хэмээн зөвшөөрч өргөмжилсөнгүй” (13.т.43.) тухай Б. Буянчуулганы зохиолд тэмдэглэгджээ.

Японы монголч эрдэмтэн Мияваки Жюнкo: - “Галдан 1671 онд чоросын /Зүүнгар аймгийн - И.С./ удирдагч байсан. Далай ламын зөвшөөрсөн хунтайж цол бол Зүүнгарын (чоросын - И.С.) удирдагч болохынх нь цол, хан нь дөрвөн ойрадыг удирдах гэсэн утгатай” (9.т.83.) гэснээс үзэхэд Галдан бошогт болон бусад ойрадын тэргүүлэгчдийн хан цолыг зөвхөн Зүүнгар хийгээд Түвдэд л зөвшөөрсөн төдий.

Академич Ш. Бира: - “Эртний монголчуудын дунд хан цолтон эрх дархтай болохынхоо хэрээр Монголын нийгэмд төр улс бүрэлдэх үйл явцад үлэмж тус нэмэр болсон байна. XII-XIII зуунд Монголын нутагт Хэрэйд, Найман, Мэргэд, Татар, Хамаг Монгол (Онон, Хэрлэн, Туул гурван гурван голын эхний монголчууд) зэрэг иргэдийн томоохон нэгдлүүд буюу овог аймгуудын холбоод буй болж, тэдгээрийг хад, тэдэнтэй тэнцэх цолтон (ван, тигитхури, бек зэрэг) толгойлж байжээ. Тэдгээр хадын толгойлж байсан иргэдийн нэгдлүүдийг бид ханлигууд хэмээн нэрлэдэг. Гэхдээ тэдгээр ханлигийг жинхэнэ улс байсан хэмээн тооцож болохгүй” (17.т.24-25.) гэснээс үзвэл Галдан бошогт Зүүнгарыг нэгэн жолоонд оруулж Зүүнгарын төр улс бүрэлдэх үйл явцад чухал үүрэг гүйцэтгэжээ.

Оросын эрдэмтдийн бүтээлд “Джунгарское ханство” хэмээн орчуулгагүй томъёолсон, суурь агуулга нь владычество, правитель, эсвэл предводитель буюу феодал ноёны эзэмшил хэмээн

тодорхойлсон харагдана. 1915 оны Хиагтын Хаант Орос, Дундад иргэн, Монгол гурван этгээдийн хэлэлцээрийн үеэр оросын төлөөлөгчдийн тэргүүн А.Я. Миллер VIII Богдын хаан цолыг нухацтай эсэргүүцсэн мэдэгдэлтэй агаар нэгэн бүлгээ. Хаант Оросын төлөөлөгчдийн тэргүүн А.Я. Миллерээс: - “Орос улсаас Марокко, Гуулин, Бухар зэрэг бага буурай орнуудтай эрт хожид байгуулсан хэлэлцээрт тэдгээрийн тэргүүлэгч нарын цолыг ер орчуулж дуудлагыг нь хөндсөнгүй, тэр хэвээр баримт бичигт буулгасан. Египетийн хааныг хетив гэдэг, энэ бол сүлд амарвайн цол, орос хэлэнд үл орчуулагдах учир нэрийг хэвээр үлдээсэн. Тэдгээр орны хадыг оросын феодал хэмээн ойлгож тийн нэрийдсэн, Монгол үүн лүгээ адил бөлгөө” (14.т.131.) гэсэн байдаг. Уг статусаар ч Хаант Орос, манжийн Чин улс хоёр Зүүнгартай харьцаж байсан нь тодорхой. Эдгээрийг үндэслэвэл Зүүнгарын ханы эзэмшил нэгдэл буюу ханлиг болох нь эргэлзээгүй.

Чорос аймгийн эзэд хан цол олсонтой холбоотой Монголын түүх бичлэгт Зүүнгарын хан, зүүнгарын хаан, Зүүнгарын хант улс, Зүүнгарын хаант улс, ойрадын хан, ойрадын хаан, Ойрадын хант улс, Ойрадын хаант улс гэсэн өвөр хоорондоо эрс ялгаа зөрчилтэй, түүхэн төр улсын улс төрийн нэр томъёоллыг түүхчид гаргажээ. Хан цолыг нэгэнт хаан болгож Галдан бошогтыг хаан өргөмжилж, Зүүнгарын нэгдэл буюу ханлигийг тусгаар улсаар тунхаглаж шинжлэх ухааны эргэлтэнд хэвшүүлсэн байдал ажиглагдана. Түүхэн сурвалж бичигт тэмдэглэгдсэн бодит нэр мөн үү? асуудал дэвшүүлэхэд эргэлзээтэй нь гарцаагүй, тийм бус нь ч тодорхой. Сурвалж баримтанд хан цол тэмдэглэгдсэн тул хэрэглэх нь гарцаагүй, тэхдээ түүхэн ёсоор бодитой байваас зохилтой. Харин өвөр монголын До. Оюунбилиг, Н. Хасбагана, Сэцэнт нар (20) Галдан бошогтын үеийн ойрадыг “Зүүнгарын ханлиг” (15) гэж тодорхойлсон нь зөв болно.

Тэр тусмаа ойрадын хан, хаан гэсэн томъёолол хэрэглэх нь авцалдахгүй байна. Ойрад нь угсаатны ч хувьд, төр улсын ч хувьд Монгол улсын бүрэлдэхүүнд явсан угсаатан, гагц хан захирч байсангүй, салбарласан овог аймгуудыг зэрэгцэн тус тусын тайж, хунтайж, хан цолтон нар удирдаж явсан бөлгөө. Тухайлбал, Ижил мөрөнд суурьшсан халимагийн Аюук хан, Хөх нуурын торгуудыг Гүүш хан захирч байв. Ойрад гэж нийт Баруун Монголыг зааж буй, Зүүнгар нь ойрад угсаатны нийтлэгийн бүрэлдэхүүн хэсгийн нэр юм.

Бас чоросын тэргүүлэгчид хан, хаан цолыг хавсран хэрэглэж байсан юм уу? гэсэн асуулт ч тавигдана. Монголын түүхэнд хан, хаан цолыг албан ёсоор хавсран хэрэглэж байсан хүн бол гагц Түшээт хан юм. 1915 оны гурван этгээдийн Хиагтын хурал дээр монголын элч нарын хэлсэн нь: - “Монгол бол Түшээт хан, Засагт хан, Сайн ноён хан, Сэцэн хан зэрэг дөрвөн хантай бөгөөд манжийн захиргааны үед Түшээт ханд олгосон тамганы сийлбэрт хаан гэж бичсэн нь бусад хануудыг тэргүүлнэ гэсэн санаа юм. Хэрэв хятадууд хэлсэнчлэн хан гэж зөвшөөрвөл Богд хаан улсын эзэн хаан байтугай Түшээт ханаас доор зиндаанд очих болж байгаа юм” (16.т.60.) гэж байжээ.

Өгүүлсэн бүхэндээ тулгуурлаваас Зүүнгарын гагц эзний үндсэн цол нь хунтайж бөгөөд түвдээс олгосон хан цол нь урамшуулал төдий өргөмжлөгдсөн тул түүхийн бүтээлд хан цолтойгоор авч Зүүнгарын хан хэмээвээс зохилтой. Зүүнгарын засаг захиргааны албан тушаалыг хөөн нягталсан эрдэмтдийн бүтээлд ч хаан гэсэн цолны судалгаа байдаггүй билээ. Зүүнгарын тэргүүлэгчдийг хаанд

өргөмжилсөн явдал хэрхэвч сурвалжийн тулгуур баримтгүй, эрдэмтэн судлаачдын зохиомж нэр томъёо гэлтэй. Угсаатан судлал хийгээд нийгэм-соёлын антропологиод этноцентрист гажуудал гэж томъёолдог нь энэ болой.

Ашигласан ном зохиол

1. “Монголын түүх”. 11 жилийн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн 8-р ангид үзнэ. – УБ.,2005.
2. “Монголын түүхийн бага нэвтэрхий толь”. Боть 3. С-Я. – УБ.,2002.
3. Далай Ч. Ойрад Монголын түүх. – УБ.,2002.
4. Намсрай. Зүүн гар хаант улсын түүх. ӨМАХХ.,1996.
5. Баабар. Монголчууд: Нүүдэл, суудал. – УБ.,2006.
6. Санждорж М. Монгол төрийн түүхээс. Гутдугаар дэвтэр. – УБ.,2007.
7. Златкин И. Я. История Джунгарского ханства (1635-1758). – М.,1964.
8. Нацагдорж Ш. Халхын түүх. – УБ.,2008.
9. Мөнхцэцэг Т. Япон дахь Монголын судалгаа. (1990-2005). – УБ.,2006.
10. Намсрай. Зүүнгар хагаант улсын түүх. - ӨМАХХ,1996.
11. “БНМАУ-ын түүх”. Дэд боть. – УБ.,1968.
12. “Монголын түүхийн бага нэвтэрхий толь”. Боть 3. С-Я. – УБ.,2002.
13. Буянчуулган Б. Дөрвөн ойрадын түүх”. – УБ.,2008.
14. Саруул И. ХХ зууны эхэн үеийн Монголын нутаг дэвсгэр. – УБ.,2005.
15. Оюунбилиг Боржигдой. Хошууд товчоон”. – ӨМАХХ.,1991.
16. И. Саруул. Д. Хүүхэнбаатар. Гурван нэрийн нэг цолны учир. – “Монгол судлалын бичиг” сэтгүүл. №1. 1992.
17. Ш. Бира. Монголын төрт ёсны түүхийн зарим онцлог асуудлууд. – “Mongolica. An international annual Mongol studies”. Vol.18(39). 2006.
18. Б. Оюунбилиг. Шолой зэрэг дөрвөн сэцэн хан суусан тухай архидын баримтууд ба холбогдох асуудлууд. - “Mongolica. An international annual Mongol studies”. Vol.18(39). 2006.
19. И. Саруул. Цэвээнравдан хаан. – УБ.,2001.
20. Н. Хасбагана, Сэцэнт. Манжийн ноёрхол доорх Монголчууд. – ӨМАХХ.,2009.

Abstract

Historical records prove that leaders of Zuungar state had the titles of prince (khuntaij), khan and khaan. The question raised is which of the titles is correct. As we consider its development in political and social status, the title prince seems to be correct. The title khan was proclaimed by Tibet as a supplementary identification. It got changed in telling as khaan with long vowels due to Mongolian pronunciation.